**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ**

---

# Говь-Алтай аймгийн Чандмана сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код**: ГАА-2025/047/НА-СТА-ТШЗ



| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Аудитор: Э.Сүнжидмаа<br>Утас: 80048599 Цахим хаяг:sunjidmaae@audit.gov.mn<br>Аудитор: А.Цээням<br>Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com |



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 04 № 92

танай ____________ -ны № ____________ -т

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.НАНСАЛМАА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй болович өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5, 15.1.7 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс багуудад спортын арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээнд 3,700.0 мянган төгрөгийг зарцуулсан;

8225020234

- Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас 592.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл, 1,680.0 мянган төгрөгийн нормын хувцасны зардлаас бүх албан хаагчдад хувцас худалдан авсан;
- Тайлант онд 6,000.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй;
- Нэмэлт санхүүжилтийн дансанд сумын орон нутгийн орлогод төвлөрөх 1,040.0 мянган төгрөгийн газар, тагтааны орлогын мөнгө төвлөрсөн байхад зарцуулсан;
- нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн сумын 100 жилийн ойн дэмжлэгийг баярын урилга хэвлэх, ойн медаль хийлгэх, гарын бэлэг дурсгалын зүйлийн бусад үйл ажиллагаанд 97,150.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан зэрэг нийт 110,162.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 100 жилийн ой тохиож орон нутгийн төсвөөс сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээнд 100.000.0 мянган төгрөгийг хүлээн авснаас 21,600.0 мянган төгрөгийг урилга хэвлүүлэхэд, 48,100.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйл худалдан авахад, 30,300.0 мянган төгрөгийг наадмын үйл ажиллагаанд */тайз засал, хөтлөгч, дуу бичлэг/* зарцуулсан байна.

Иргэд, байгууллагаас 726,823.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авч, 30,055.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 11,283.6 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 54,191.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 хөтөлбөр, 15 зорилт, 103 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж биелэлтийн тайланг нийт дүнгээр 98.0 хувиар үнэлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 116,767,933.91 | 135,330,613.91 |
| 33 | АВЛАГА | 49,002,220.00 | 37,000,200.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 49,002,220.00 | 19,500,200.00 |
| 335 | Бусад авлага | - | 17,500,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 17,500,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 67,765,713.91 | 98,330,413.91 |
| 354 | Хангамжийн материал | 22,765,698.91 | 53,330,398.91 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 260,000.00 | 260,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,505,698.91 | 53,070,398.91 |
| 35600 | Мал амьтад | 45,000,015.00 | 45,000,015.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,162,129,730.71 | 1,765,180,712.45 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,162,129,730.71 | 1,765,180,712.45 |
| 392 | Биет хөрөнгө | 1,047,158,730.71 | 1,650,522,212.49 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 766,598,179.87 | 1,220,183,496.87 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (248,522,895.12) | (300,051,876.10) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 133,022,920.00 | 165,897,920.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (53,889,582.65) | (61,807,292.67) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 51,030,064.00 | 59,308,590.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (17,490,245.92) | (20,168,147.56) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 27,820,900.00 | 26,336,055.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,535,876.96) | (10,313,979.16) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | - | 99,800,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | - | (1,330,666.68) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 580,166,492.30 | 655,742,191.30 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (182,041,224.81) | (183,074,078.51) |
| 393 | Биет бус хөрөнгө | 114,971,000.00 | 114,658,499.96 |
| 39301 | Програм хангамж | 625,000.00 | 625,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (312,500.04) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 114,346,000.00 | 114,346,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,278,897,664.62 | 1,900,511,326.36 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 3,656,778.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 3,656,778.00 |
| 413 | Өглөг | - | 3,656,778.00 |
| 4136 | Бусад өглөг | - | 3,656,778.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 3,656,778.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,278,897,664.62 | 1,896,854,548.36 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,278,897,664.62 | 1,896,854,548.36 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 205,561,280.37 | 205,561,280.37 |
| 51101 | Өмч: - төрийн | 205,561,280.37 | 205,561,280.37 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 954,412,316.08 | 1,576,739,756.74 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 954,412,316.08 | 958,782,873.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 617,956,883.74 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 118,924,068.17 | 114,553,511.25 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,278,897,664.62 | 1,900,511,326.36 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **994,067,247.00** | **1,841,899,046.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **322,893,838.00** | **784,333,463.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 322,893,838.00 | 784,333,463.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 322,893,838.00 | 784,333,463.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө | 322,893,838.00 | 754,278,463.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Материал | | 30,055,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **671,173,409.00** | **1,057,565,583.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,373,709.00 | 140,309,283.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,088,709.00 | 138,814,283.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,285,000.00 | 1,495,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 567,799,700.00 | 917,256,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 567,799,700.00 | 917,256,300.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **776,417,673.32** | **1,223,942,162.26** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **776,417,673.32** | **1,223,942,162.26** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 732,352,214.05 | 1,138,332,084.43 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 354,996,523.73 | 593,963,854.91 |
| 210101 | Үндсэн цалин | 354,996,523.73 | 593,963,854.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,665,080.45 | 74,250,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,679,480.45 | 50,754,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,246,400.00 | 5,873,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,797,100.00 | 2,936,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,300.00 | 2,936,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,492,800.00 | 11,747,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,129,233.15 | 50,310,755.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,358,853.15 | 4,359,277.26 |
| 210302 | Түлш, халаалт | 36,570,380.00 | 45,451,478.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 82,729,105.40 | 40,795,273.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,996,780.00 | 4,655,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,435,262.40 | 27,000,553.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,762,300.00 | 2,304,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,266,000.00 | 6,415,300.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 45,848,763.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,000,000.00 | 9,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 9,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,780,000.00 | 18,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,780,000.00 | 18,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,996,600.00 | 50,781,520.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,511,600.00 | 49,236,720.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 604,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 485,000.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 179,055,671.32 | 300,730,681.26 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,129,750.00 | 136,103,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 136,925,921.32 | 164,627,481.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 44,065,459.27 | 85,610,077.83 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,549,206.00 | 42,702,130.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 32,730,630.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,549,206.00 | 9,971,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 27,516,253.27 | 42,907,947.83 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,516,253.27 | 42,907,947.83 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **217,649,573.68** | **617,956,883.74** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 20,982,391.31 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 20,982,391.31 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (20,982,391.31) | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 196,667,182.37 | 617,956,883.74 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

( төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **671,173,409.00** | **1,106,567,803.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **671,173,409.00** | **1,106,567,803.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,373,709.00 | 189,311,503.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,088,709.00 | 138,814,283.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,285,000.00 | 50,497,220.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 567,799,700.00 | 917,256,300.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 567,799,700.00 | 917,256,300.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **652,973,709.00** | **1,093,167,803.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **652,973,709.00** | **1,093,167,803.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **559,906,029.73** | **985,786,577.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 354,996,523.73 | 602,492,906.91 |
| 210101 | Үндсэн цалин | 354,996,523.73 | 602,492,906.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 44,665,080.45 | 74,250,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,679,480.45 | 50,754,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,246,400.00 | 5,873,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,797,100.00 | 2,936,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 449,300.00 | 2,936,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,492,800.00 | 11,747,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,129,233.15 | 46,653,977.26 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,358,853.15 | 4,359,277.26 |
| 210302 | Түлш, халаалт | 36,570,380.00 | 41,794,700.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 34,816,842.40 | 38,334,973.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,996,780.00 | 4,655,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,435,262.40 | 27,000,553.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,762,300.00 | 2,304,420.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,202,500.00 | 3,955,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 5,000,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,000,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,000,000.00 | 9,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,000,000.00 | 9,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 14,780,000.00 | 18,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,780,000.00 | 18,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 17,435,000.00 | 57,481,520.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,950,000.00 | 55,936,720.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 604,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 485,000.00 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | - | 500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 44,083,350.00 | 139,073,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 44,083,350.00 | 139,073,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **93,067,679.27** | **107,381,225.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 16,549,206.00 | 44,973,078.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 35,001,578.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,549,206.00 | 9,971,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 76,518,473.27 | 62,408,147.83 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 27,516,253.27 | 42,907,947.83 |
| 213405 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,002,220.00 | 19,500,200.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **18,199,700.00** | **13,400,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **18,199,700.00** | **13,400,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **18,199,700.00** | **13,400,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 18,199,700.00 | 13,400,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 18,199,700.00 | 13,400,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(18,199,700.00)** | **(13,400,000.00)** |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 205,561,280.37 | 121,180,611.32 | 755,522,590.56 | 1,082,264,482.25 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 2,222,543.15 | 2,222,543.15 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **205,561,280.37** | **121,180,611.32** | **757,745,133.71** | 1,084,487,025.40 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | (2,256,543.15) | 0.00 | (2,256,543.15) |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 196,667,182.37 | 196,667,182.37 |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **205,561,280.37** | **118,924,068.17** | **954,412,316.08** | 1,278,897,664.62 |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **205,561,280.37** | **118,924,068.17** | **954,412,316.08** | 1,278,897,664.62 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 4,370,556.92 | 4,370,556.92 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **205,561,280.37** | **118,924,068.17** | **958,782,873.00** | 1,283,268,221.54 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | (4,370,556.92) | 0.00 | (4,370,556.92) |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 617,956,883.74 | 617,956,883.74 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **205,561,280.37** | **114,553,511.25** | **1,576,739,756.74** | 1,896,854,548.36 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **928,539,900.00** | **874,348,352.17** | 54,191,547.83 | 94.16 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **928,539,900.00** | **874,348,352.17** | 54,191,547.83 | 94.16 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **882,299,900.00** | **829,375,274.17** | 52,924,625.83 | 94.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 594,000,000.00 | 591,692,906.91 | 2,307,093.09 | 99.61 |
| 210101 | Үндсэн цалин | 594,000,000.00 | 591,692,906.91 | 2,307,093.09 | 99.61 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 74,250,000.00 | 74,250,000.00 | 0.00 | 100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,754,800.00 | 50,754,800.00 | 0.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,873,800.00 | 5,873,800.00 | 0.00 | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,936,900.00 | 2,936,900.00 | 0.00 | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,936,900.00 | 2,936,900.00 | 0.00 | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,747,600.00 | 11,747,600.00 | 0.00 | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 47,144,700.00 | 46,653,977.26 | 490,722.74 | 98.96 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,850,000.00 | 4,359,277.26 | 490,722.74 | 89.88 |
| 210302 | Түлш, халаалт | 41,794,700.00 | 41,794,700.00 | 0.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 38,982,000.00 | 32,928,190.00 | 6,053,810.00 | 84.47 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,200,000.00 | 4,200,000.00 | 0.00 | 100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 29,500,000.00 | 23,541,770.00 | 5,958,230.00 | 79.80 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,400,000.00 | 2,304,420.00 | 95,580.00 | 96.02 |
| 210404 | Ном, хэвлэл | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 120,000.00 | 120,000.00 | 0.00 | 100.00 |
| 210406 | *Бага үнэтэй, түргэн элэгдэх,* ахуйн эд зүйлс | 2,462,000.00 | 2,462,000.00 | 0.00 | 100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,500,000.00 | 15,500,000.00 | 0.00 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,000,000.00 | 6,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,500,000.00 | 9,500,000.00 | 0.00 | 100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 18,000,000.00 | 18,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18,000,000.00 | 18,000,000.00 | 0.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 68,423,200.00 | 24,427,000.00 | 43,996,200.00 | 35.70 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 65,832,200.00 | 22,882,200.00 | 42,950,000.00 | 34.76 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,150,000.00 | 604,800.00 | 545,200.00 | 52.59 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 330,000.00 | - | 330,000.00 | 0.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 95,000.00 | - | 95,000.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66,000.00 | - | 66,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 440,000.00 | 10,000.00 | 97.78 |
| 210807 | Газрын төлбөр | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,000,000.00 | 25,923,200.00 | 76,800.00 | 99.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,000,000.00 | 25,923,200.00 | 76,800.00 | 99.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 46,240,000.00 | 44,973,078.00 | 1,266,922.00 | 97.26 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 46,240,000.00 | 44,973,078.00 | 1,266,922.00 | 97.26 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 36,240,000.00 | 35,001,578.00 | 1,238,422.00 | 96.58 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,000,000.00 | 9,971,500.00 | 28,500.00 | 99.72 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **928,539,900.00** | **874,348,352.17** | **54,191,547.83** | **94.16** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **928,539,900.00** | **874,348,352.17** | **54,191,547.83** | **94.16** |
| 122005 | Орон нутгийн төсвөөс | 928,539,900.00 | 874,348,352.17 | **54,191,547.83** | **94.16** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 27 | 22 | **5** | |
| 620001 | Удирдах ажилтан | 8 | 8 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13 | 10 | **3** | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | | |
| 620004 | Гэрээт ажилтан | 4 | 2 | **2** | |

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **103,373,709.00** | **189,311,503.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **103,373,709.00** | **189,311,503.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 54,371,489.00 | 169,811,303.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 19,800,000.00 | 10,800,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 19,800,000.00 | 10,800,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,221,489.00 | 5,406,783.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 700,000.00 | 455,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,318,989.00 | 3,458,783.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 202,500.00 | 1,493,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 15,350,000.00 | 40,454,520.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,350,000.00 | 40,454,520.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,000,000.00 | 113,150,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,000,000.00 | 113,150,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **49,002,220.00** | **19,500,200.00** |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **49,002,220.00** | **19,500,200.00** |
| 213405 | *Төвлөрүүлэх шилжүүлэг* | *49,002,220.00* | *19,500,200.00* |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 103,373,709.00 | 189,311,503.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,373,709.00 | 189,311,503.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,000,000.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 97,088,709.00 | 138,814,283.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,285,000.00 | 50,497,220.00 |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 30,570.9 мянган төгрөгийн 3 алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

**Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**

- Санхүүгийн тайланд Нийтийн бие засах байгууламж барих арга хэмжээний зардалд Нутгийн оргил групп ХХК-д олгосон 17,500.0 мянган төгрөгийг авлагаар бүртгэж тайлагнаагүй,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ нийтийг хамарсан ажлын ажлын цалин ХЭДС-аас шилжиж ирсэн 10,800.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд цалингийн зардлаар тайлагнасан.
- Ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн аудитаар илүү олгосон 2,270.9 мянган төгрөгийг цалингаас суутган тооцоод үр дүнгийн тайланд тухайн зардлыг бууруулаагүй цалингийн зардлыг бууруулж тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 110,162.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 110,162.0 мянган төгрөгийн 5 зөрчил[2] илэрч 3,312.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 106,850.0 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүллээ.

**Төлбөрийн акт**

1.Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орсон тагтаа ногтрууны хураамж 240.0 мянган төгрөг, Тахь ресурс ХХК-аас газрын төлбөр 800.0 мянган төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлээгүй үйл ажиллагааны зардалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.4-т "агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж", 23.8.14-т "газрын төлбөр"; 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"; гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь</u>:Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Байгууллагын нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 592.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан, албан хаагчдад нормын хувцасны зардлаас 1,680.0 мянган төгрөгийг ойн

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

арга хэмжээний хүрээнд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс 5 багийн сургалт, спорт арга хэмжээний зардалд 3,700.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2.Цахим дэлгүүрээс 6,000.0 мянган төгрөгийн комьпютер, бусад хөрөнгийг худалдан авалт хийгээгүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Улсын төсвөөс 100 жилийн ойн дэмжлэгт олгосон санхүүжилтээс 2,850.0 мянган төгрөгийг хуучин барилга нураах цэвэрлэх ажилд зарцуулсан, үлдэгдэл 97,150.0 мянган төгрөгийг сумын ойн урилга хэвлэхэд 21,600.0 мянган төгрөг, ойн медальд 4,750.0 мянган төгрөг, гарын бэлэг дурсгалын зүйлийн үнэнд 48,100.0 мянган төгрөг, талбайн засал чимэглэлд 7,700.0 мянган төгрөг, нээлт дуу бичлэгт 4,000.0 мянган төгрөг, хөтлөгчийн хөлсөнд 2,000.0 мянган төгрөг, бусад үйл ажиллагааны зардалд 9,000.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох"; 15.1.5-т “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;" 15.1.7-т



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлэе.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: Залруулсан | | Үүнээс: Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Чандмана сумын ЗДТГ | 3 | 33,873.6 | 3 | 33,873.6 | | | 3 | 33,873.6 | | | | |
| Дүн | 3 | 33,873.6 | 3 | 33,873.6 | | | 3 | 33,873.6 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Чандмана сумын ЗДТГ | 5 | 110,162.0 | 2 | 3,312.0 | 3 | 106,850.0 | | | - | - | | |
| Дүн | 5 | 110,162.0 | 2 | 3,312.0 | 3 | 106,850.0 | | | - | - | - | - |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо: Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр: Санал дүгнэлт гаргасан | Түүврт хамруулсан | Аудит хийгээгүй | Санал дүгнэлтийн хэлбэр: Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |

-----------оОо-----------



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР